

“ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАР ОЛГОХ ХӨТӨЛБӨР”-ИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОН ДАВТАН СУРГАЛТ-2018

Нэг. “ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН УР ЧАДВАР ОЛГОХ ХӨТӨЛБӨР”-ИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОН ДАВТАН СУРГАЛТ

1.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах сургалтын байгууллагын онол болон дадлагын байртай танилцах ажлыг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын А/10 тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн хугацаанд хийж сургалтын бүртгэлийн бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулахаар эрх авсан 64 сургалтын байгууллага хүсэлт ирүүлж гэрээ байгуулан хамтран ажиллахаар болж онол болон дадлагын байртай нь танилцан, хяналт хийн ажиллалаа.

Сургалтын байгууллагууд нь Нийслэлийн төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дүүргээр нь авч үзвэл Сүхбаатар дүүрэгт 16, Чингэлтэй дүүрэгт 12, Баянгол дүүрэгт 13, Баянзүрх дүүрэгт 8, Сонгинохайрхан дүүрэгт 6, Хан-Уул дүүрэгт 9 тус тус байна.

1.2. 2018 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар 1160 иргэнд 27 сургалтын төрлөөр 53 сургалтын байгууллагуудад ур чадвар олгох сургалтуудад хамрагдан төгсөөд байна. Төрлөөр авч үзвэл:


- Хүнсний ногооны фермер-22
- Машин механизм, төхөөрөмжийн оператор-26
- Даралтат савны оператор буюу түгээгч-10
- Хөнгөн үйлдвэрлэлийн оёдол, эсгүүр-266
- Хөнгөн үйлдвэрлэлийн оёдол, эсгүүр мэргэшүүлэх-32
- Хөнгөн үйлдвэрлэлийн сүлжигч, нэхэгч-1
- Хатгамал, эсгий, даавуу урлал-14
- Арьс ширэн урлал-3
- Гутал үйлдвэрлэл-3
- Гар урлал бэлэг дурсгал-9
- Модон эдлэлийн мужаан-10
- Талх нарийн боов-5
- Хоол үйлдвэрлэл, тогооч-21
- Сүү цагаан идээ боловсруулах-25
- Кран өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины оператор-7
- Засал, чимэглэл-37
- Цахилгаанчин-51
- Гагнуурчин-16

- Сантехникч-7
- Автомашины засвар-2
- Гар утасны засварчин-5
- Үсчин-105
- Гоо засалч-70
- Гэрийн асаргаа үйлчилгээний ажилтан-23
- Цэцэрлэгийн багшийн туслах ажилтан-312
- Худалдагч касс, нярав-67
- Нарийн бичиг-албан хэргийн ажилтан-11 тус тус байна.

Нийт 1160 иргэн суралцсанаас эмэгтэй 928 буюу 80%, ажилгүй иргэн 1111 буюу 96%, ажилд өртөж болзошгүй иргэн 49 тус тус байна.



Боловсролын түвшингээр: Бага дунд боловсролтой 16, бүрэн бус дунд боловсролтой 31, бүрэн дунд боловсролтой 799, дээд боловсролтой 250, техникийн мэргэжилтэй 36, тусгай дунд боловсролтой 28 иргэд байна.



Дүүргээр: Баянгол 121, Баянзүрх 306, Сонгинохайрхан 295, Сүхбаатар 118, Хан-Уул 105, Чингэлтэй 122, хөдөө орон нутгийн харьяалалтай 89 иргэд байна.

1.3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ болон салбарын хөгжлийн бодлого, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого түүний хэрэгжилтийг сурталчлах, бодлого үйл ажиллагаагаа таниулах,



иргэдэд үзүүлж байгаа ажил үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг таниулах, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчдийн ур чадварыг үнэлэх, тэднийг дэмжих зорилгоор Хөдөлмөр халамжийн, үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар хамтран өдөрлөгийг 2018 оны 09



дүгээр сарын 20-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах арга хэмжээний хүрээнд **34** мэргэжлийн сургалтын байгууллага үйл ажиллагаагаа **3274** иргэнд сурталчилсан ба гар хивс, арьсан урлал, эсгий урлал, ороолт малгай, загварын дээл, хавтага, олбог болон бусад төрлийн бараа бүтээгдэхүүнийг танилцуулж **1.020.000** төгрөгийн борлуулалт хийсэн байна.

1.3.1. МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН УРАЛДААН-2018 ТЭМЦЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн Мэргэжлийн болон давтан сургалтанд хамрагдсан иргэдийн дунд үсчин, нүүр будалт, хумс засал, оёдлын чиглэлээр ур чадварын уралдааныг зохион байгууллаа.

Уралдаанд оёдолчин мэргэжлээр **29** иргэн, үсчин мэргэжлээр **9** иргэн, нүүр будалтаар **5** иргэн, хумс засалтаар **4** иргэн оролцож ур чадвараа сорилоо.

Хумс заслын төрөлд:

- 1-р байр “Сарамежик” сургалтын төвийн Г.Оюунтунгалаг,
- 2-р байр “Голден бүүк” сургалтын төвийн Ө.Тунгалагтуяа,

3-р байр “Дистрой” сургалтын төвийн Б.Номинтуул,

Үсчингийн төрөлд:

1-р байр “Дипломат” сургалтын төвийн С.Буджав,

2-р байр “Цэнгэл-Сор” сургалтын төвийн Б.Наранцэцэг,

3-р байр “Агаар мандал орчин” сургалтын төвийн Л.Алимаа,

Нүүр будалтын төрөлд:

1-р байр “”Дистрой” сургалтын төвийн Б.Өнөртулга,

2-р байр “Дистрой” сургалтын төвийн Б.Солонго,

3-р байр “Сарамежик” сургалтын төвийн Д.Нарантуяа,

Оёдлын төрөлд :

1-р байр “Уран зээ-Од” сургалтын төвийн Ш.Баярцогт,

2-р байр “Цогц үйлчилгээ” сургалтын төвийн Б.Мөнхзул,

3-р байр “Үлэмж чанар” сургалтын төвийн С.Даваасүрэн нар эзэлж тус бүр өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР